

**ГХБХБГ-ЫН 05 ДУГААР САРЫН 3 ДАХЬ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,
СУДАЛГАА**

2017.05.19

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>2017 оны 05 дугаар сарын 11-15-ний өдрүүдэд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын ЗУХАГ-ийн ахлах мэргэжилтэн Г.Мөнхзултай ажлын хэсэг байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, онц сайн дүнгээр дүгнэсэн болно.</p> <p>СӨХ-ийн нийтийн эзэмшил газрыг тогтоох ажлын хэсэг байгуулагдлаа.</p> <p>Аймгийн “Тирлик” захын урьд талын замын дагуу нийтийн эдэлбэр газарт зөвшөөрөлгүй худалдаа, наймаа хийж байгаа иргэдэд газар чөлөөлөх тухай хугацаатай мэдэгдэх хуудас өгч, аймгийн МХГ-тай хамтран газар чөлөөлөх тал дээр арга хэмжээ авч ажиллаж байна.</p> <p>Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5 дахь заалтыг дагуу “Ак-дам” зах, “Тирлик” зах, “Файн ноос” ХХК, “Жанатохыма” ХХК, “Эрчимбаян-Өлгий” ХХК, “Паккал” ХХК, А.Айнагүл нар өөрсдийн хөрөнгөөр газрын мэргэжлийн байгууллага “Баялаг Увс” ХХК-нд захиалгаар газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа хийлгэсэн болно.</p> <p>Аймгийн ОБГазарт 2017.04.25-нд 173 дугаар албан бичгээр Өлгий сумд ашиглагдаж байгаа барилга байгууламжийн судалгааг хүргүүлэв.</p> <p>2017 оны 05 дугаар сарын 18-ний өдөр Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төвөөс ирсэн ажлын хэсэгт Баян Өлгий аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын бүтээн байгуулалтын ажлууд, Барилгын материалын лабораторийн үйл ажиллагаатай танилцав. Мөн Цэнгэл</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

суманд ажиллаж ирлээ.

Өлгий сумын 5-р багийн нутаг дэвсгэрт 2-р бүрэн дунд сургуулийн зүүн талд ерөнхий төлөвлөгөө зөрчиж, ерөнхий төлөвлөгөөгөөр заагдсан авто замын дээр давхцуулан барилга баригдаж байгаа байдлыг шалгуулахаар аймгийн МХГазарт санал хүргүүлсэн ба ажлыг түр зогсоох тухай тухайн иргэнд ГХБХБГазрын даргын албан тоотыг хүргүүлэв.

Т.Авдигажийн гудамжинд барих авто зогсоол, иргэн М.Хуатын хувийн хаус орон сууцны байршлыг Р.Тилеубекийн үйлчилгээний барилгын байршлыг тус тус хангагч байгууллагуудтай зөвшөөрөлцөн баталсан.

Засгийн газраас зохион байгуулж буй хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн талаархи сургалтад суув.

Өлгий хотын Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд дүгнэлт хянаж, цаашид авах арга хэмжээний төлөвлөж байна.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР